


Алтны тухай ойлголт



Алт нь *Aurum* буюу *Үүрийн туяа* гэсэн утгатай Латин үгнээс гаралтай. Алт нь байгаль дээр цэврээр (дангаараа) орших ба хувийн жин ихтэй (хүнд) металл юм.

Алтны хамгийн онцгой чанар нь ус болоод агаарын нөлөөнд автагдаггүй явдал юм.

Алт цианы уусмалд задарч Au_4 нэгдлийг үүсгэдэг учир алтыг ялган авахад цианы хүчлийг хэрэглэх тохиолдол байдаг.

Цэвэр алт нь ихэнхи тохиолдолд 30-50 % ийн мөнгөний хольцтой байдаг. Үүнээс гадна түүний найрлагад зэс төмөр зэрэг зарим эрдэс бага хэмжээтэй байдаг.

Одоо үед алтны 2 төрлийн ордыг түшиглэн олборлолт хийдэг.

1. Үндсэн орд
2. Шороон орд

Цэвэр алтны агуулгыг сорьц гэх бөгөөд хэрэв алтны сорьц 900 гэвэл тэр нь түүний найрлагад цэвэр алт 90% байна гэж үзнэ.

Алтны нөөц ихтэй, дэлхийн томоохон орд газрууд, түүнд түшиглэсэн уурхайнууд:



1. Грасберг (Индонез)
2. Йоханнесбургийн уурхай (ӨАБНУ)
3. Лихир (Папуа Шинэ Гвиней)
4. Олимпиада (ОХУ)
5. Пуэбло Виэхо (Доминикан)
6. Боддингтон (Австрали)
7. Паскуа Лама (Аргентин, Чили)
8. Карлин (АНУ)
9. Кортез (АНУ)



10. Мпоноенг (ӨАБНУ)

2015 онд хамгийн их алт олборлосон улсууд:

1. БНХАУ 490 тонн
 2. Австрали 300 тонн
 3. ОХУ 242 тонн
 4. АНУ 200 тонн
 5. Канад 150 тонн
 6. Перу 150 тонн
 7. ӨАБНУ 140 тонн
 8. Мексик 120 тонн
 9. Узбекистан 103 тонн
 10. Гана 85 тонн
- 2015 онд Монгол улс ойролцоогоор 15 тонн алт олборлосон.